



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/74/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Архангай аймаг Өлзийт сум 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Монголиан бизнес рейтинг аудит ХХК Утас: 70005329 Цахим хаяг:mbr.audit.llc@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ П.БАТЧУЛУУН
ТАНАА

Тодор. од. од. № 76

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд халаалтын зардлын 71.8 сая төгрөгийн өр төлбөр үүсгэж хуримтлагдсан өрийн үлдэгдэл 514.1 сая төгрөгт хүрсэн, худалдан авах ажиллагааны тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 46.1.4, 46.1.5 заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



T. Baygalmaa

Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>29,639,434.23</u>	<u>35,459,608.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	28,533,398.00	35,459,608.00
351	Түүхий эд материал	976,000.00	5,124,650.00
35130	Эм боох материал	976,000.00	5,124,650.00
354	Хангамжийн материал	27,557,398.00	30,334,958.00
35420	Аж ахуйн материал	26,557,398.00	29,359,798.00
35440	Түлш, шатах тослох материал	1,000,000.00	975,160.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,480,713,785.28</u>	<u>2,435,033,993.02</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,480,713,785.28	2,435,033,993.02
392	Биет хөрөнгө	2,447,433,785.28	2,401,753,993.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,344,974,237.32	4,363,699,937.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,025,445,022.48	-2,084,163,607.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	140,660,981.56	152,901,100.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	-80,606,119.94	-93,120,763.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	223,792,123.37	225,692,123.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	-189,213,542.97	-202,160,997.17
39217	Ном	33,271,128.42	38,906,199.32
393	Биет бус хөрөнгө	33,280,000.00	33,280,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	33,280,000.00	33,280,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,510,353,219.51</u>	<u>2,470,493,601.02</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	442,276,056.17	514,103,697.00
413	Өглөг	442,276,056.17	514,103,697.00
4136	Бусад өглөг	442,276,056.17	514,103,697.00
41361	Байгууллагад төлөх өглөг	442,276,056.17	514,103,697.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,068,077,163.34</u>	<u>1,956,389,904.02</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,068,077,163.34	1,956,389,904.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,080,102,877.97	1,080,102,877.97
51101	Өмч: - төрийн	1,080,102,877.97	1,080,102,877.97
512	Хуримтлагдсан үр дүн	-2,352,951,557.25	-2,464,638,816.57
51210	Өмнөх үеийн үр дүн	-2,352,951,557.25	-2,352,951,557.25
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-111,687,259.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,340,925,842.62	3,340,925,842.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,510,353,219.51</u>	<u>2,470,493,601.02</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,385,987,352.02	1,309,528,633.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	60,737,552.02	38,267,889.90
120	Нийтлэг татварын бус орлого	60,737,552.02	38,267,889.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	60,737,552.02	6,065,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,588,800.00	3,882,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	201,939,600.00	207,551,943.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	201,939,600.00	198,682,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	201,939,600.00	198,682,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,123,310,200.00	1,063,708,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,869,843.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,869,843.64
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,428,259,920.36	1,421,215,892.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,428,259,920.36	1,421,215,892.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,396,309,650.36	1,389,282,877.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	892,541,400.00	846,534,513.23
210101	Үндсэн цалин	607,097,900.00	589,687,200.00
210102	Нэмэгдэл	208,520,200.00	184,793,413.23
210104	Урамшуулал	76,923,300.00	72,053,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,243,730.54	114,830,456.23
210201	Тэтгэврийн даатгал	84,736,630.54	83,283,656.23
210202	Тэтгэмжийн даатгал	8,876,700.00	7,886,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,101,400.00	6,309,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,775,300.00	1,577,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,753,700.00	15,773,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,408,735.40	272,304,430.60
210301	Гэрэл, цахилгаан	5,880,113.00	5,759,503.00
210302	Түлш, халаалт	248,843,122.40	265,244,927.60
210303	Цэвэр, бохир ус	685,500.00	1,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,287,003.00	7,775,273.64
210401	Бичиг хэрэг	1,129,800.00	1,049,143.64
210402	Тээвэр, шатахуун	4,500,000.00	3,792,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,256,500.00	788,300.00
210404	Ном, хэвлэл	308,903.00	332,780.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	229,900.00	70,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,861,900.00	1,742,650.00
2105	Нормативт зардал	45,133,700.00	42,471,015.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,605,200.00	12,699,950.00
210502	Хоол, хүнс	41,427,000.00	28,926,385.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,101,500.00	844,680.00
210604	Урсгал засвар	13,819,400.00	-
2107	Томилолт, зочны зардал	524,900.00	137,200.00
210702	Дотоод албан томилолт	524,900.00	137,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,778,600.00	11,649,617.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,978,600.00	10,849,617.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,572,181.42	93,580,372.16

Архангай аймгийн Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,219,230.00	9,399,690.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,352,951.42	84,180,682.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,950,270.00	31,933,015.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,879,410.00	31,816,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,909,660.00	30,266,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	969,750.00	1,550,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,070,860.00	116,415.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,070,860.00	116,415.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(42,272,568.34)</u>	<u>(111,687,259.32)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(42,272,568.34)</u>	<u>(111,687,259.32)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,327,838,600.00</u>	<u>1,275,143,343.64</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,588,800.00	3,882,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,588,800.00	3,882,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,588,800.00	3,882,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,588,800.00	3,882,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,325,249,800.00	1,271,260,743.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	201,939,600.00	198,682,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	201,939,600.00	198,682,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,123,310,200.00	1,063,708,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,869,843.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,869,843.64
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,327,838,600.00</u>	<u>1,268,845,343.64</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,327,838,600.00	1,268,845,343.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,294,151,600.00	1,236,912,328.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	892,541,400.00	847,349,200.00
210101	Үндсэн цалин	592,499,000.00	589,687,200.00
210102	Нэмэгдэл	223,119,100.00	185,608,100.00
210104	Урамшуулал	76,923,300.00	72,053,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,444,300.00	113,815,200.00
210201	Тэтгэврийн даатгал	84,937,200.00	82,268,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,876,700.00	7,886,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,101,400.00	6,309,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,775,300.00	1,577,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,753,700.00	15,773,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	188,119,600.00	198,682,100.00
210301	Гэрэл, цахилгаан	6,509,600.00	5,759,600.00
210302	Түлш, халаалт	180,210,000.00	191,622,500.00
210303	Цэвэр, бохир ус	1,400,000.00	1,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,375,400.00	8,136,543.64
210401	Бичиг хэрэг	1,129,800.00	1,049,143.64
210402	Тээвэр, шатахуун	4,500,000.00	3,792,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,499,900.00	788,400.00
210404	Ном, хэвлэл	724,900.00	332,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	419,900.00	432,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,100,900.00	1,741,800.00
2105	Нормативт зардал	45,568,600.00	47,131,685.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,605,200.00	16,471,300.00
210502	Хоол, хүнс	41,623,400.00	28,926,385.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,340,000.00	1,734,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,820,000.00	-
210604	Урсгал засвар	13,820,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	524,900.00	137,200.00
210702	Дотоод албан томилолт	524,900.00	137,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,058,400.00	9,255,500.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,258,400.00	8,455,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,699,000.00	12,404,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,699,000.00	12,404,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,687,000.00	31,933,015.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,616,140.00	31,816,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,348,140.00	30,266,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,268,000.00	1,550,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,070,860.00	116,415.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,070,860.00	116,415.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	<u>6,298,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	<u>6,298,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	<u>6,298,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	6,298,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	6,298,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	<u>-6,298,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,080,102,877.97	3,340,925,842.62	(2,310,678,988.91)	2,110,349,731.68
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,080,102,877.97	3,340,925,842.62	(2,310,678,988.91)	2,110,349,731.68
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,749,827.48	2,749,827.48
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,080,102,877.97	3,340,925,842.62	(2,352,951,557.25)	2,068,077,163.34
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,080,102,877.97	3,340,925,842.62	(2,352,951,557.25)	2,068,077,163.34
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,080,102,877.97	3,340,925,842.62	(2,352,951,557.25)	2,068,077,163.34
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(111,687,259.32)	(111,687,259.32)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,080,102,877.97	3,340,925,842.62	(2,464,638,816.57)	1,956,389,904.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,262,390,900.00	1,262,274,485.00	(116,415.00)	100.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,262,390,900.00	1,262,274,485.00	(116,415.00)	100.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,230,574,300.00	1,230,457,885.00	(116,415.00)	100.0%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	847,349,200.00	847,349,200.00	-	100.0%
210101	Үндсэн цалин	589,687,200.00	589,687,200.00	-	100.0%
210102	Нэмэгдэл	185,608,100.00	185,608,100.00	-	100.0%
210104	Урамшуулал	72,053,900.00	72,053,900.00	-	100.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,815,200.00	113,815,200.00	-	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	82,691,900.00	82,268,400.00	(423,500.00)	99.5%
210202	Тэтгэмжийн даатгал	7,780,800.00	7,886,500.00	105,700.00	101.4%
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,224,700.00	6,309,400.00	84,700.00	101.4%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,556,100.00	1,577,400.00	21,300.00	101.4%
210205	Эрүүл мэндийн даатгал	15,561,700.00	15,773,500.00	211,800.00	101.4%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	198,682,100.00	198,682,100.00	-	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	5,759,600.00	5,759,600.00	-	100.0%
210302	Түлш, халаалт	191,622,500.00	191,622,500.00	-	100.0%
210303	Цэвэр, бохир ус	1,300,000.00	1,300,000.00	-	100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	7,678,500.00	7,678,500.00	-	100.0%
210401	Бичиг хэрэг	591,100.00	591,100.00	-	100.0%
210402	Тээвэр, шатахуун	3,792,400.00	3,792,400.00	-	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	803,200.00	788,400.00	(14,800.00)	98.2%
210404	Ном, хэвлэл	443,600.00	332,700.00	(110,900.00)	75.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	454,900.00	432,100.00	(22,800.00)	95.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,593,300.00	1,741,800.00	148,500.00	109.3%
2105	Нормативт зардал	47,248,100.00	47,131,685.00	(116,415.00)	99.8%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,471,300.00	16,471,300.00	-	100.0%
210502	Хоол, хүнс	29,042,800.00	28,926,385.00	(116,415.00)	99.6%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,734,000.00	1,734,000.00	-	100.0%
2107	Томилолт, зочны зардал	137,200.00	137,200.00	-	100.0%
210702	Дотоод албан томилолт	137,200.00	137,200.00	-	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,259,100.00	11,259,100.00	-	100.0%

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,459,100.00	10,459,100.00	-	100.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	-	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,404,900.00	4,404,900.00	-	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,404,900.00	4,404,900.00	-	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,816,600.00	31,816,600.00	-	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,816,600.00	31,816,600.00	-	100.0%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,266,600.00	30,266,600.00	-	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,550,000.00	1,550,000.00	-	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,262,390,900.00	1,262,274,485.00	(116,415.00)	100.0%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,262,390,900.00	1,262,274,485.00	(116,415.00)	100.0%
131001	Улсын төсвөөс санхүүжих	198,682,100.00	198,682,100.00	-	100.0%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,063,708,800.00	1,063,592,385.00	(116,415.00)	100.0%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	58.00	58.00	-	100.0%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	43.00	43.00	-	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	-	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	63.00	63.00	-	100.0%
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	41.00	41.00	-	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22.00	22.00	-	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,752,443.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,752,443.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,752,443.64
2104	Хангамж, бараа материалын зардал	458,043.64
210401	Бичиг хэрэг	458,043.64
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,294,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,294,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8000000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8869843.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,869,843.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,869,843.64

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Солонготуяа, аудитор А.Жамъян нар гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер Н.Алтанзул, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Багшийн хөгжлийг хангаж, суралцагч бүрийн сурлагын чанарт ахиц гаргаж, эрүүл аюулгүй тохилог орчин бүрдүүлэхэд оршино”.

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Сургалт хүмүүжлийн ажлын чанар хүртээмжийг дээшлүүлж, багш ажиллагсдын хамтын оролцоог хэрэгжүүлэх;
- Багш суралцагчийг үнэлэх үнэлгээний шинэ журмыг хэрэгжүүлж, багшийн зохицуулах цагийг үр өгөөжтэй ашиглах;
- Сургалтын орчин нөхцөл, сурах бичгийн хангамжийг сайжруулан, сурах бичгийг төлбөртэй ашиглуулах, үйлчилгээг нэвтрүүлж, орчны эрүүл ахуйн стандартыг баримтлан ажиллах;
- Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг сайжруулж, эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.;
- Насан туршийн боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, бүх насны хүн амыг тасралтгүй суралцах боломжийг нэмэгдүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн

Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсүгэй”

- Монгол Улсын Засгийн газрын 2021 онд баталсан Үдийн хоолны норматив тогтоох тухай 237 дугаар тогтоолын 1-д “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 1500 төгрөг”, 2-д “...6-9 дүгээр ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2022 оны 9-р сарын 1-ний өдрөөс 1800 төгрөг”-өөр тогтоосугай гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага дотоод хяналтын журам, заавар боловсруулж, баталгаажуулаагүй байна.

Дотоод хяналтын комисс нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, хяналт хийж, тайланг захирлын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна. Харин дотоод хяналтыг зөвхөн сургалтын үйл ажиллагаа, анги танхимын эрүүл ахуй, хүүхдийн эрүүл мэнд, хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлагын хүрээнд хийж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг дунд гэж үнэлэн 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,428.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 21.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39.9 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс, богино хугацаат өр төлбөрийн данс байна.

. Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	28.5	35.5	6.9
Биет хөрөнгө	2,447.4	2,401.8	(45.7)
Биет бус хөрөнгө	33.3	33.3	-
Нийт хөрөнгө	2,510.4	2,470.5	(39.9)
Богино хугацаат өр төлбөр	442.3	514.1	71.8
Засгийн газрын оруулсан капитал	1,080.1	1,080.1	-
Хуримтлагдсан үр дүн	(2,353.0)	(2,464.6)	(111.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,340.9	3,340.9	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,510.4	2,470.5	(39.9)

3.5.1. Бараа материалын дансны үлдэгдэл 35.5 сая төгрөг болж 6.9 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 105.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар 2.2 сая төгрөгийн аж ахуйн материал хүлээн авч, 100.4 сая төгрөгийн материал зарцуулсан нь нөлөөлсөн байна. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

3.5.2. Биет хөрөнгө дансны үлдэгдэл 45.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд БШУЯ-аас 3.0 сая төгрөгийн сурах бичиг, Архангай аймгийн боловсролын газраас 7.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, Өлзийт сумын ЗДТГ-аас 18.7 сая төгрөгийн төмөр хашаа хүлээн авсан, 6.3 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг Архангай аймгийн төрийн өмчийн газрын зөвшөөрлөөр худалдан авч, тайлант онд 84.2 сая төгрөгийн элэгдлийн зардал гарснаас шалтгаалжээ.

3.5.3. Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл (2,464.6) сая төгрөг болж 111.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 62.9 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлого 22.5 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 7.0 сая төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт бараа үйлчилгээний бусад зардалд гарсан байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая.төг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,325.2	1,262.4	(62.9)
Үндсэн үйл ажиллагааны орлого	60.7	38.3	(22.5)
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8.9	(8.9)
Үйл ажиллагааны орлого	1,386.0	1,309.5	(76.5)
Цалин, шимтгэлийн зардал	1,012.8	961.4	(51.4)
Бусад бараа үйлчилгээний зардал	310.4	322.7	12.3

Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4.8	11.6	6.9
Бараа үйлчилгээний бусад зардал	54.6	93.6	39.0
Урсгал шилжүүлэг	32.0	31.9	(0.1)
Хөрөнгө шилжүүлсэн	-	-	-
Үйл ажиллагааны зардал	1,428.3	1,421.2	(7.0)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(42.27)	(111.69)	(69.4)

Тус газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 62.9 сая төгрөг буюу 4.7 хувиар буурсан нь цар тахалтай холбоотойгоор хичээл сургалтын үйл ажиллагааг цахим, танхим хосолсон хэлбэрт шилжүүлсэнтэй холбоотойгоор санхүүжилт буурсан байна. Тайлант онд 84.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал гарсан нь үйл ажиллагааны нийт үр дүн буурахад нөлөөлсөн байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 1,011.5 сая, орон нутгийн төсвөөс 204.1 сая, нийт 1,215.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Тайлант хугацаанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолыг үндэслэн сумын төсөвт 2 удаа өөрчлөлт оруулж, төсвийг 66,088.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,200,256.2 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 9,636.6 мянган төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 77,690.0 мянган төгрөгөөр өсгөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,262.4 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 1,063.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 198.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,063.6 сая, орон нутгийн төсвөөс 198.7 сая, нийт 1,262.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,262.3 сая төгрөгийг зарцуулж 100 гүйцэтгэлтэй ажилласан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,262.3 сая төгрөг буюу 100.0 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

БШУС-ын 2021 оны А/280 дугаар тушаалаар “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн 8.0 сая, түрээсийн номын үнэ 3.7 сая, дээд шатны байгууллагуудаас 1.1 сая төгрөг, нийт 12.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 12.7 сая төгрөг буюу 100 хувь зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал гараагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн шууд захирагч нь төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зэрэг төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллаагүйн улмаас жил бүр халаалтын өр төлбөр хуримтлагдаж 514.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хууль 8 дугаар зүйлийн 8.2-д “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйн улмаас босго үнэ давсан 28.2 сая төгрөгийн үдийн хоолны хүнсний материалыг нэг компанид давуу эрх олгон шууд худалдан авалт хийсэн байна.

Тус байгууллага нь хууль тогтоомжид нийцүүлээгүй, төсвийг бүлэг хооронд шилжүүлэн зориулалт бусаар зарцуулахад тавих хяналт сул байгааг цаашид анхаарах шаардлагатай.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:
 - Тайлант онд хоол хүнсний зардлыг 0.1 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.
2. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллагаас хандив тусламж хүлээн аваагүй байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 73 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээллэж 76 мэдээллийг хугацаа хоцроосон, жилийн эцсийн санхүүгийн тайланг оруулаагүй буюу хамааралгүй мэдээлэл оруулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.4, 6.5.6 дахь заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг бүрэн оруулаагүй зөрчил давтан гарч байгаа тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг тулган шалгахад батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, байр ашиглалттай холбоотой зардлыг 20-оос доошгүй хувийг хэмнэж ажиллаагүй, бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулж ажиллаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1, 1.8 дахь заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж, зөрчил арилгах 3 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 75 хувьтай байгаа ба шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 542.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, 4 албан шаардлага, 1 төлбөрийн акт хүргүүлэв.

Залруулагдаагүй 7 алдаа, зөрчлийн дүн 542.3 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 16.1 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Төлбөрийн акт

Хонхор Автомашины шатахуун зарцуулалтыг давтан тооцоолж, шалгах горим хэрэгжүүлэхэд 0.4 сая төгрөгийн шатахуун илүү зарцуулсан байна. Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 тушаалаар батлагдсан Жишиг норм батлах тухай тушаал /Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм/ хавсралттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4.2 Албан шаардлага

1. Тайлант онд Өлзийт сумын ерөнхий боловсролын сургууль нь жишиг сургууль болох зорилтын хүрээнд Долоон бар ХХК-тай хийсэн гэрээний дагуу өмнөх онуудаас хуримтлагдаж ирсэн халаалтын зардлын 514.1 сая төгрөгийн өр үүссэн байна. Тус сургуулийн түлш, халаалтын батлагдсан төсөв нь зардлыг бүрэн санхүүжүүлж чадахгүй тул ирээдүйд төсвийн ачаалал үүсгэх эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар

зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1.5 "Энэхүү журмын 1.4 д зааснаас бусад тохиолдолд Дотоод хяналтыг зохион байгуулах журмыг тухайн байгууллага аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.

Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд худалдан авалтын тендер зарлалгүй Алтайн цайдам ээж ХХК-аас 28.1 сая төгрөгийн хоол хүнсний материалыг шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ" баримталж ажиллах, босго үнээс давсан худалдан авах ажиллагаанд нээлттэй тендер, харьцуулалтын аргыг ашиглах.

Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шуудан холбоо, интернэтийн төлбөр /210403/ зардлын данснаас 0.1 сая төгрөгийн ариутгалын хөлс, 0.02 сая төгрөгийн маягтын үнэ, 0.7 сая төгрөгийн хэвлэлийн зардлыг гаргасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Өлзийт сумын ЕБС	5	542.5			1	0.4	2	542.3	2	0.2
Дүн		5	542.5			1	0.4	2	542.3	2	0.2
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Өлзийт сумын ЕБС	2	-					2	-	-	-
Дүн		2	-					2	-	-	-
Нийт дүн		7	542.5			1	0.4	4	542.3	2	0.2



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар

1/10330/23

Цэцэрлэг

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Аудитаар автомашины 100 км гүйлтэд зарцуулах жишиг нормоос хэтрүүлэн 441.1 мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан "Жишиг норм батлах тухай" /Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм/ заавартай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6 "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү зарцуулсан 441.073.00 (дөрвөн зуун дөчин нэгэн мянга далан гурван) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Архангай аймгийн орон нутгийн төсвийн орлогын Ар Бусад нэр заагдаагүй орлогын 100010000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Архангай аймаг дахь аудитын газарт ирүүлэхийг Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал П.Батчулуун, нягтлан бодогч Э.Одбаяр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
"МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.НЭРГҮЙБААТАР
Д.ТҮМЭНЖАРГАЛ





АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022

оны

02

сарын

25

өдөр

Дугаар

116/1030/13

Цэцэрлэг

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Аудитаар тайлант онд халаалтын зардлын өр үүсгэж оны эцэст нийт 514,103.6 мянган төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Архангай аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал П.Батчулуун, нягтлан бодогч Э.Одбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.НЭРГҮЙБААТАР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ

"МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.ТҮМЭНЖАРГАЛ





АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 199/00330613

Цэцэрлэг

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Аудитаар байгууллагын шилэн дансанд байршуулбал зохих 149 мэдээллээс 76 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, ил тод байршуулах 1 мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4 “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11 “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”, 2021 оны А/108 тушаалын хэвсрэлтаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 3.1.1 “Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй бол зөрчил арилгах албан шаардлага өгөх” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж мэдээллийг нөхөн байршуулан биелэлтийг 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал П.Батчулуун, нягтлан бодогч Э.Одбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.НЭРГҮЙБААТАР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
“МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.ТҮМЭНЖАРГАЛ

